**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/188 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар 27.5.14, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2024 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд зүй бусаар хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах, булшлах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг эрчимжүүлэх, хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах сумын Онцгой комисст дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиглэлийг 1 дүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар, зохион байгуулалтын арга хэмжээний зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Ажлын хэсгийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр) Онцгой байдлын газрын дарга, хошууч (С.Ганболд) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Удирдамжид заасан арга хэмжээг 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж, ажлын тайлан мэдээг аймгийн Онцгой комисс, Шуурхай штабт тухай бүр танилцуулж, мэдээллээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.

4.Зохион байгуулалтын арга хэмжээтэй холбоотой шаардлагатай зардлыг Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

5.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010577

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 22-ны өдрийн А/... дугаар
Захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН,ЧИГЛЭЛ

**Төмөрбулаг, Галт, Жаргалант, Шинэ-Идэр сум**

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Мөнх-Эрдэнэ (Мал эмнэлгийн газрын албаны дарга)
Ажлын хэсгийн гишүүд С.Анхбаяр (Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч ахмад)
Б.Тунгалаг (Хүнс хөдөө аж ахуйн газрын Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын улсын байцаагч)
Г.Энхманлай (Онцгой байдлын газрын жолооч )

**Цагаан-Уул, Цэцэрлэг, Бүрэнтогтох сум**

Ажлын хэсгийн ахлагч: Л.Ариунаа (Мал эмнэлгийн газрын дарга )
Ажлын хэсгийн гишүүд Б.Батдорж (Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч)
Х. Чүлтэм (Салаан захирагч дэслэгч)
Х.Пүрэвханд ( Хүнс хөдөө аж ахуйн газар Хоол үйлдвэрлэл үйлчилгээний хяналтын улсын байцаагч)
Жолооч (Дэлгэрмөрөн сав газрын захиргааны жолооч)

**Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Түнэл, Мөрөн, Рашаант сум**

Ажлын хэсгийн ахлагч: П.Мөнхжаргал (Байгаль орчин,аялал жуулчлалын газрын дарга)
Ажлын хэсгийн гишүүд Б.Сожидмаа (Мал эмнэлгийн газрын мэргэжилтэн )
Л.Бямбасүрэн (Гамшгийн улсын хяналтын ахлах байцаагч хошууч)
Жолооч (Байгаль орчин аялал жуулчлалын газрын жолооч)

**Арбулаг, Баянзүрх, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур**

Ажлын хэсгийн ахлагч: Я.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө ахуйн газрын дарга)
Ажлын хэсгийн гишүүд Б.Мягмарсүрэн ( Мал эмнэлгийн газрын улсын байцаагч)
Л.Ганзориг (Эрэн хайх аврах салбарын бүлгийн дарга аврах,ажиллагааны зааварлагч хошууч)
Жолооч (Хүнс, хөдөө аж ахуйн газрын жолооч)

**Алаг-Эрдэнэ, Хатгал, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Эрдэнэбулган, Ханх**

Ажлын хэсгийн ахлагч: Л.Долгорсүрэн ( Мал эмнэлгийн лабораторын эрхлэгч)
Ажлын хэсгийн гишүүд С.Дэмбэрэлням (Гал түймрийн улсын хяналтын байцаагч ахлах дэслэгч)
Жолооч (Боловсрол,шинжлэх ухааны газрын жолооч)

-oOo-

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 22-ны өдрийн А/188 дугаар
Захирамжийн 2 дугаар хавсралт

**УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго:**

1.1. Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэр, Хүнс,хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 25-ний өдрийн А/125 дугаар захирамж, 2024 оны 4 дүгээр сарын 05-ний өдрийн А/154 тоот захирамжийн хүрээнд өвөлжилт, хаваржилтын хүндрэлээр зүй бусаар хорогдсон малын хүүр, сэг, зэмийг цуглуулах, устгах, бэлчээр, бууц, хашаа хороо, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх, халдваргүйтгэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах, үйл ажиллагаа эрчимжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээ, мэдээллийг шуурхай солилцох.

**Хоёр.Хамрах хүрээ:** 23 сум, 1 тосгон, 81 баг

**Гурав.Хийх ажил:**

2.1. Сумын Онцгой комисс, Шуурхай штабын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шууд удирдлагаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

2.2. Малын сэг, зэмийг устгах арга хэмжээг 7 хоногийн хугацаанд зохион байгуулах, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах, шаардлагатай хүн хүч хэрэгслийг татан оролцуулах;

2.3. Орон нутгийн онцгой комисс, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2.4. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, дайчлан ажиллуулах хүн хүч, техник, тоног төхөөрөмж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг тодотгох, хамтран ажиллах;

2.5. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, тандалтын арга хэмжээг эрчимжүүлэх, малын хөдөлгөөнд хяналт тавих, чиглэлээр үүрэг өгч бүртгэлийг чангатгах;

2.6. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах бэлтгэл, бэлэн байдлыг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах

2.7 Ажлын хэсгүүд ажлын тайланг зургаар баталгаажуулан аймгийн Мал эмнэлгийн газар, Шуурхай штабд ирүүлэх.

**Гурав. Гарах үр дүн:**

3.1.Аймгийн хэмжээнд малын хүүр, сэг, зэмийг цуглуулах, устгах, бэлчээр, бууц, хашаа хороо, уст цэг, усны эх булгийг цэвэрлэх, халдваргүйтгэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.

**Дөрөв: Хугацаа:**

4.1. Ажиллах хугацаа: 2024 оны 4 дүгээр сарын 21-ны өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл

-оОо-

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 22-ны өдрийн А/188 дугаар
Захирамжийн 3 дугаар хавсралт

# АЖЛЫН ХЭСГИЙН ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ ШАТАХУУН, ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| Ажлын хэсэг | Сумын нэр | Баг | Шатахууны зардал | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Явах км | Сум дотор | Нийт км | 100 км-т 18-аар | АИ-92 | Нийт үнэ |
| 1-р хэсэг | Мөрөн-Түнэл | 6 | 55 | 120 | 175 | 32 | 2,590 | 81,585 |
| | Тосонцэнгэл | 5 | 84 | 130 | 214 | 39 | 2,580 | 99,382 |
| | Рашаант | 5 | 75 | 150 | 225 | 41 | 2,750 | 111,375 |
| | Их-Уул | 5 | 50 | 150 | 200 | 36 | 2,580 | 92,880 |
| | Тариалан | 5 | 45 | 230 | 275 | 50 | 2,750 | 136,125 |
| | Тариалан-Мөрөн | 14 | 160 | 0 | 160 | 29 | 2,750 | 79,200 |
| | | | | | | | | **600,547** |
| 2-р хэсэг | Мөрөн-Төмөрбулаг | 5 | 75 | 250 | 325 | 59 | 2,580 | 150,930 |
| | Галт | 5 | 85 | 250 | 335 | 60 | 2,580 | 155,574 |
| | Жаргалант | 5 | 65 | 250 | 315 | 57 | 2,590 | 146,853 |
| | Шинэ-Идэр | 4 | 60 | 235 | 295 | 53 | 2,750 | 146,025 |
| | Шинэ-Идэр-Мөрөн | | 140 | 0 | 140 | 25 | 2,750 | 69,300 |
| | | | | | | | | **668,682** |
| 3-р хэсэг | Мөрөн-Цагаан-Уул | 6 | 140 | 300 | 440 | 79 | 2,590 | 205,128 |
| | Цэцэрлэг | 7 | 80 | 300 | 380 | 68 | 2,950 | 201,780 |
| | Бүрэнтогтох | 6 | 165 | 200 | 365 | 66 | 2,580 | 169,506 |
| | Бүрэнтогтох-Мөрөн | | 60 | | 60 | 11 | 2,580 | 27,864 |
| | | | | | | | | **604,278** |
| 4-р хсэг | Мөрөн-Арбулаг | 5 | 75 | 130 | 205 | 37 | 4,560 | 168,264 |
| | Баянзүрх | 5 | 65 | 130 | 195 | 35 | 4,560 | 160,056 |
| | Улаан-Уул | 6 | 110 | 200 | 310 | 56 | 4,560 | 254,448 |
| | Цагаан-Нуур | 2 | 90 | 120 | 210 | 38 | 4,560 | 172,368 |
| | Ренчинлхүмэ | 6 | 60 | 200 | 260 | 47 | 4,560 | 213,408 |
| | Ренчинлхүмэ-Мөрөн | | 245 | 0 | 245 | 44 | 4,560 | 201,096 |
| | | | | | | | | **1,169,640** |
| 5-р хэсэг | Мөрөн-Алаг-эрдэнэ | 5 | 65 | 120 | 185 | 33 | 2,750 | 91,575 |
| | Хатгал | 1 | 45 | 60 | 105 | 19 | 2,850 | 53,865 |
| | Ханх | 3 | 180 | 120 | 300 | 54 | 2,850 | 153,900 |
| | Чандмань-Өндөр | 4 | 140 | 120 | 260 | 47 | 2,780 | 130,104 |
| | Цагаан-Үүр | 4 | 65 | 120 | 185 | 33 | 2,780 | 92,574 |
| | Эрдэнэбулган | 5 | 130 | 120 | 250 | 45 | 2,690 | 121,050 |
| | Эрдэнэбулган-Мөрөн | | 170 | 0 | 170 | 31 | 2,690 | 82,314 |
| | | | | | | | | **725,382** |
| **Аймгийн дүн** | | **124** | **2779** | **4,005** | **6,784** | **1,221** | | **3,768,529** |

| Ажлын хэсэг | Ажиллах сум | Томилолтын зардал | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ажиллах хүний тоо | Хоног тоо | Нэгж зардал | Нийт зардал |
| 1-р хэсэг | 6 | 4 | 7 | 90,000 | 2,280,000 |
| 2-р хэсэг | 4 | 4 | 7 | 90,000 | 1,800,000 |
| 3-р хэсэг | 3 | 5 | 7 | 90,000 | 1,950,000 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4-р хэсэг | | 5 | 4 | 7 | 90,000 | 2,040,000 |
| 5-р хэсэг | | 6 | 3 | 7 | 90,000 | 1,710,000 |
| | Нийт | | | 35 | | 9,780,000 |

НИЙТ ЗАРДАЛ

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Шатахууны зардал | мян/төг | 3,768,529 |
| 2 | Томилолтын зардал | мян/төг | 9,780,000 |
| | Бүгд | | 13,548,529 |

-оОо-